



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 420

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18 -ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн 3 ширхэг, нийт 38,800,000.00 (гучин найман сая найман зуун мянга) төгрөгийн балансын үнэ 19,441,666.60 (арван есөн сая дөрвөн зуун дөчин нэгэн мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий ашиглалтын хугацаа дуусч дахин үнэлгээ хийгдсэн автомашинуудыг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Тогтоолд заасан төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нар, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батмэнд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 1 дугаар сарын 28-ны өдрийн  
 1/2023/1 дугаар албан бичгийн хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСЧ,  
 ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД БҮРТГЭХ АВТОМАШИНУУДЫН ЖАГСААЛТ

| Д/д | Хөрөнгө<br>эзэмшигч төрийн<br>өмчит<br>байгууллага | Шилжүүлэх<br>Автомашинны нэр, марк,<br>арлын дугаар          | Улсын |        | Үйлдвэр-<br>лэсэн он<br>/Ашиглалта<br>д орсон он | Хөрөнгийн<br>балансын үнэ<br>(төгрөг)      | Хуримтлагд-<br>сан элэгдэл<br>(төгрөг)   | Бүртгэх<br>байгууллага                       |
|-----|--|--|-------|--------|--|--|--|--|
|     |  |  | Сери  | Дугаар |  |  |  |  |
| 1   | Соёлын өвийн<br>үндэсний төв                       | Тоёота Ландкрузер-100<br>/арлын дугаар<br>UZJ1000021219/     | УНИ   | 2241   | 1998/2006  | 18,500,000.00                              | 6,475,000.00   | Завхан аймгийн<br>Цагаанчулуут<br>сумын ЗДТГ |
| 2   | Байгалийн түүхийн<br>музей                         | Тоёота Ландкрузер-100<br>/арлын дугаар<br>JTECJ09J905511033/ | УББ   | 9933   | 2005/2006  | 8,000,000.00                               | 666,666.60   | Завхан аймгийн<br>Шилүүстэй сумын<br>ЗДТГ    |
| 3   | Татварын ерөнхий<br>газар                          | Тоёота Вохи /арлын<br>дугаар AZR600045172/                   | УБҮ   | 0296   | 2002/2010  | 12,300,000.00                              | 12,300,000.00  | Завхан аймгийн<br>Хөгжимт жүжгийн<br>театр   |
|     |  |  |       |        |  | <b>38,800,000.00</b>                       | <b>19,441,666.60</b>   |  |
|     |  |  |       |        |  | (гучин найман<br>сая найман зуун<br>мянга) | (арван есөн сая<br>дөрвөн зуун<br>дөчин нэгэн<br>мянга зургаан<br>зуун жаран<br>зургаан төгрөг<br>жаран мөнгө) |  |

Нийт дүн